



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/88

Төмөрбулаг сум

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус сумын нутаг дэвсгэрт дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж “Мөнх-Хүсэл-Од” ХХК-нд ЗДТГ-ын эзэмшилд байдаг 0000020190 газар эзэмших гэрчилгээний дугаартай гүний худгийн уснаас үйл ажиллагаандаа ус авч ашиглахыг 3 (гурван) жилийн хугацаагаар зөвшөөрсүгэй.

2.Ус ашиглах зөвшөөрөл олгох дулаан үйлдвэрлэгч “Мөнх-Хүсэл-Од” ХХК-нд ашиглах усны хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Хавсралтад заасан дулаан үйлдвэрлэлийн “Мөнх-Хүсэл-Од” ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилт, төлбөр төлөлт, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Ч.Амаржаргал)-д болон Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Хишигсайхан) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



А.МӨНХЭРДЭНЭ